



**НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/80

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.17, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 3/05 дугаар тогтоол, Дүүргийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ зохион байгуулах тухай А/10 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн орон нутгийн төсвийн 750,000,000 (долоон зуун тавин сая) төгрөгийн хөрөнгөөр санхүүжих “Баянгол Шинэ Өргөө” ОНӨААТҮГ-ын хог тээврийн авто машин худалдан авах ажил”-ыг зохион байгуулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Б.Алтансүх

Худалдан авах ажиллагааны ахлах мэргэжилтэн

Гишүүд:

А.Нэмэхбаатар

Төрийн, захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн

А.Энхцэцэг

Үндэсний аж үйлдвэрийн Зөвлөл ТББ-ын гишүүн (зөвшилцсөнөөр)

Б.Анудар

Худалдан авах үйл ажиллагааны хөтөч ТББ-ын гишүүн (зөвшилцсөнөөр)

Нарийн бичгийн дарга:

А.Алтангэрэл

Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, үр дүн гүйцэтгэлийг тайлагнаж ажиллахыг Үнэлгээний хороо (Б.Алтансүх)-нд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ө.СУМЪЯАБААТАР

1160200396